



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02

Бөхт

2024 оны цэргийн бүртгэл явуулах тухай

Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/322 дүгээр тушаалаар батлагдсан Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам, аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/708 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны Цэргийн бүртгэл явуулах сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга Б.Амгаланжаргал (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүдэд Т.Үрлээ (Нийгмийн эрүүл мэндийн ажилтан)

М.Оюунбаяр (Насан туршийн боловсролын

нэгжийн багш)

Э.Сумъяа (1 дүгээр багийн Засаг дарга)


Д.Шинэбаяр (2 дугаар багийн Засаг дарга)

М.Цэвэгдорж (3 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга Ө.Отгонгэрэл (Архив бичиг хэргийн эрхлэгч)

2. Сумын цэргийн алба хаах насны болон цэргийн бэлтгэл алба хаах насны иргэдийн цэргийн бүртгэлийг 2024 оны 1 дүгээр сарын 09-ны өдрөөс 25-ны дотор зохион байгуулахыг ажлын хэсэг (Б.Амгаланжаргал)-д үүрэг болгосугай.

3. Монгол Улсын дайчилгааны тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад заагдсан Улсын дайчилгааны төлөвлөгөө болон Зэвсэгт хүчний анги байгууллагын хүн хүч техникээр хангах төлөвлөгөөний дагуу сумын хуулийн этгээдүүдийн улсын дайчилгааны даалгавар (хүнс болон эд хэрэгслийн тоо) цэргийн дайчилгааны даалгаварт оногдуулан данслагдсан бэлтгэлд үүрэгтэй иргэд авто техник өөрөө явагч хэрэгсэл ангийн буу зэргийг нэг бүрчлэн бүртгэн тоолж даалгаваржуулах.



4. Бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд 2016 онд шинэчлэн батлагдсан “Батлан хамгаалах”-ын багц хууль 2018 онд батлагдсан “Орон нутгийн хамгаалалтын тухай хууль”, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр хаах журам” мөн тус оны Засгийн газрын 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн гэрээт алба хаах журам” зэрэг бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдийн тухай, цэргийн жинхэнэ алба хаах тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулан тайланг Цэргийн штабт хүргүүлэхийг ажлын хэсэг (Б.Амгаланжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ